

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ”  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХИ НИЙГМИЙН  
БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 05 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах талаархи асуудлыг хэлэлцэж, дараахь санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.2</sup>, 14<sup>1.3</sup> дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал таван жилийн хугацаагаар томилох тухай заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд даатгуулагч болон ажил олгогч талуудын төлөөлөл болсон 6 хүнийг, Засгийн газрын төлөөлөл болсон 3 хүнийг томилох талаархи асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36<sup>1</sup> дүгээр зүйлийн 36<sup>1.1</sup> дэх хэсэгт “Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэж заасныг баримтлан танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, С.Чинзориг, М.Билэгт нар нэр дэвшигчдээс асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Д.Сарангэрэл, М.Билэгт, Д.Ганболд нар эрүүл мэндийн даатгалын тогтолцоог өөрчилж, хүн бүрт хүртээмжтэй, тэгш үйлчилдэг болгох, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг Үндэсний зөвлөлийн дүрмийг хаврын чуулганы хугацаанд багтаан батлуулах нь зүйтэй зэрэг саналуудыг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, гишүүнээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярыг, Засгийн газрыг төлөөлсөн гишүүдээр Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдыг, дэд дарга, гишүүнээр даатгуулагчийн төлөөлөл Д.Дэмбэрэлийг, мөн даатгуулагчийн төлөөлөлд Ц.Цолмонгэрэл, Б.Мягмар нарыг, ажил олгогчийн төлөөлөлд Х.Ганбаатар, Ц.Ганхүү, Д.Чимэддагва нарыг томилох тухай асуудлыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.


Санал хураалтын дүнг үндэслэн “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу боловсруулан Байнгын хорооны санал, дүгнэлтэд хавсарган гишүүдэд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах талаархи Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Л.ЭНХ-АМГАЛАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

### Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.1</sup>, 14<sup>1.2</sup>, 14<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

#### 1/Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

Б.Чойжилсүрэн	-Сангийн сайд
Н.Номтойбаяр	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
А.Цогцэцэг	-Эрүүл мэндийн сайд

#### 2/Даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:

Д.Дэмбэрэл	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын орон тооны бус зөвлөх
Ц.Цолмонгэрэл	-Эрүүл мэндийн эдийн засагч, эрүүл мэндийн даатгалын шинжээч
Б.Мягмар	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

#### 3/Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

Х.Ганбаатар	-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал
Ц.Ганхүү	-“Магда” ХХК-ний ерөнхий захирал
Д.Чимэддагва	-Макро эдийн засаг ба эрүүл мэнд ТББ-ын тэрүүн

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын орон тооны бус зөвлөх Д.Дэмбэрэлийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн дэд даргаар томилсугай.

3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг боловсруулж, Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Нийгмийн



бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд ирүүлэхийг Үндэсний зөвлөл /Н.Номтойбаяр/-т даалгасугай.

Гарын үсэг

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

## Даатгуулагчийг төлөөлж:

### 1. Дамдингийн ДЭМБЭРЭЛ

1. Хэзээ, хаана төрсөн: 1941 онд Ховд аймгийн Манхан суманд төрсөн.

2. Нас, хүйс: 76 настай, эрэгтэй

3. Үндэс угсаа: Захчин

4. Гэр бүлийн байдал: Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

5. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1960 онд Ховд хотын 1 дүгээр 10 жилийн дунд сургууль, 1964 онд Эдийн засгийн дээд сургуулийг Худалдааны эдийн засаг, технологи зохион байгуулалт мэргэжлээр, 1977 онд ОХУ-ын Москва хот Нийгмийн Ухааны Академийг Улс төрийн дээд боловсрол эзэмшин тус тус төгссөн. 2001 онд Удирдлагын академид Удирдахуйн ухааны магистрын зэрэг, 2011 онд тус академид Удирдахуйн ухааны докторын зэрэг хамгаалсан.



6. Ажилласан байдал:

1964-1968 онд Ховд аймгийн Худалдаа бэлтгэлийн удирдах газрын орлогч дарга, 1968-1970 онд Ховд аймгийн МАХН-ын хороонд улс төр, гэгээрлийн кабинетэд эрхлэгч, лектор, 1970-1972 онд Ховд аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1972-1975 онд МХЗЭ-ийн Төв хорооны эвлэлийн байгууллагын хэлтсийн эрхлэгч, 1977-1984 онд МАХН-ын Төв хороонд зохион байгуулагч, 1984-1990 онд МАХН-ын Төв хороонд зохион байгуулагч, группын ахлагч, 1990-1992 онд Завхан аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1992 онд Монгол Улсын Бага Хурлын гишүүн, 1992-2016 Монгол Улсын Их Хурлын гишүүн, 1992-1996 онд УИХ дахь МАХН-ын бүлгийн дарга, 1996-2000 онд УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, 2000-2004 онд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2006 оноос УИХ-ын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга, 2007 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, 2008-2012 Монгол Улсын Их Хурлын дарга.

7. Гадаад хэл:

Орос хэлтэй.



## 2.Цилаажавын ЦОЛМОНГЭРЭЛ

- 1.Хэзээ, хаана төрсөн:** 1972 онд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд төрсөн.
- 2.Нас, хүйс:** 45 настай, эмэгтэй
- 3.Үндэс угсаа:** Халх
- 4.Гэр бүлийн байдал:** Ээжийн хамт амьдардаг.
- 5.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**



1990 онд Архангай аймгийн Цэцэрлэг хотын 10 жилийн дунд сургууль, 1995 онд Монгол Улсын Их Сургуулийн, Эдийн Засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр, 1997 онд тус сургуулийн эдийн засаг, бизнесийн удирдлагын магистр, 1999 онд Их Британи улсын Манчестрийн их сургуулийг магистр зэргээр тус тус төгссөн, эдийн засагч мэргэжилтэй, Эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

**6.Ажилласан байдал:**

1995-1996 онд МУИС-ын ЭЗС-д Бизнесийн удирдлагын багш, 1996-1997 онд Европын Холбооны Тасис хөтөлбөр, “Эдийн засгийн боловсролыг шинэчлэх хөтөлбөр”-ийн судалгааны ажилтан, 1997-1998 онд тус хөтөлбөрийн Ерөнхий зохицуулагч, 2000-2004 онд ЭМЯ-ны Стратеги төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, 2004-2006 онд АХБ-ны “Эрүүл мэндийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх” төслийн Ахлах зөвлөх, 2006-2008 онд АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-2”-т зөвлөх, 2007 онд ДЭМБ, Номхон далайн баруун эргийн бүсийн төвийн Эрүүл мэндийн санхүүжилтийн зөвлөх, 2008-2010 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Багийн ахлагч, 2008-2009 онд “Филиппин улсын эрүүл мэндийн салбарын бодлогыг дэмжих” Европын Холбооны хөтөлбөрийн зөвлөх, 2011-2012 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны “Эрүүл мэндийн даатгалыг бэхжүүлэх” төслийн Багийн ахлагч, 2012-2014 онд Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 2015 онд АХБ-ны “Хүнс тэжээл, нийгмийн хамгааллын төслийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн зөвлөх, 2015-2016 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн үндэсний тооцооны зөвлөх, 2016 онд АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оролцоог

ханган үйлчилгээг сайжруулах нь” төслийн Биеийн үйл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын мэргэжилтэн, АХБ-ны “Хүнс тэжээл, нийгмийн хамгааллын төслийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн Эрүүл мэндийн даатгалын Бизнес процессын мэргэжилтэн, 2017 оны 01 дүгээр сараас “Филиппин улсын эрүүл мэндийн салбарын бодлогыг дэмжих” Европын Холбооны төсөлд Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын шинжээчээр ажиллаж байна.

**7.Гадаад хэл:**

Орос, Англи, Герман хэлтэй.

### 3.Бямбасүрэнгийн МЯГМАР

- 1.Хэзээ, хаана төрсөн:** 1981 онд Улаанбаатар хотод төрсөн.
- 2.Нас, хүйс:** 36 настай, эмэгтэй
- 3.Үндэс угсаа:** Халх
- 4.Гэр бүлийн байдал:** Нөхөр, 3 хүүхдийн хамт амьдардаг.



- 5. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**

1998 онд Нийслэлийн 10 жилийн 20-р дунд сургууль, 2001 онд Анагаах ухааны коллежийг сувилахуй зүйч мэргэжлээр, 2008 онд Хөдөлмөрийн дээд сургуулийг Хөдөлмөрийн эдийн засагч мэргэжлээр, 2010 онд тус сургуулийг Хөдөлмөрийн эдийн засгийн магистр зэргээр тус тус төгссөн, Хөдөлмөрийн эдийн засгийн магистр зэрэгтэй.

- 6.Ажилласан байдал:**

2001-2005 онд Клиникийн 1-р амаржих газарт Сувилахуйн арга зүйч, 2005-2009 онд тус амаржих газрын Хүний нөөцийн менежер, 2009 оноос одоог хүртэл Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны даргаар ажиллаж байна.



**Ажил олгогчийг төлөөлж:**


**1.Хуягийн ГАНБААТАР**

**1.Хэзээ, хаана төрсөн:** 1957 онд Говь-Алтай аймгийн Түмэн суманд төрсөн.

**2.Нас, хүйс:** 60 настай, эрэгтэй

**3.Үндэс угсаа:** Халх

**4.Гэр бүлийн байдал:** Эхнэр хүүхдийн хамт амьдардаг.



**5.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**

1974 онд Нийслэлийн 34 дүгээр дунд сургууль, 1982 онд ЗХУ-ын Киев хотын Хөнгөн үйлдвэрийн дээд сургууль, 2012 онд Киев хотын Хөнгөн үйлдвэрийн технологийн дээд сургуулийг Техникийн шинжлэх ухааны магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн, арьс ширэн эдлэлийн инженер, технологич мэргэжилтэй.

**6.Ажилласан байдал:**

1982-1984 онд АШҮН-ийн Гутлын үйлдвэрийн инженер, цехийн дарга, 1984-1989 онд ХХҮЯ, ХҮЯ-ны инженер, ахлах инженер, хэлтсийн дарга, газрын дарга, 1989-1990 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн референт, 1990-1992 онд Хөдөлмөрийн Дэд сайд, 1992-1996 онд Худалдаа үйлдвэрийн Дэд сайд, 1996-1998 онд ХХААХҮЯ-ны Аж үйлдвэрийн газрын дарга, сайдын зөвлөх, 1998-2001 онд “Шинэ Интернейшнл” ХХК-ийн Ерөнхий захирал, 2001-2009 онд Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос одоог хүртэл тус холбооны Дэд ерөнхийлөгч, гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

**7.Гадаад хэл:**

Орос, англи хэлтэй.

## 2.Цээхүүгийн ГАНХҮҮ

**1.Хэзээ, хаана төрсөн:**

1955 онд Ховд аймгийн  
Дарви суманд төрсөн.

**2.Нас, хүйс:**

62 настай, эмэгтэй

**3.Үндэс угсаа:**

Халх

**4.Гэр бүлийн байдал:**

Нөхрийн хамт амьдардаг.

**5.Хэзээ, хаана, ямар  
сургууль төгссөн мэргэжил,  
эрдмийн зэрэг, цол:**

1972 онд Ховд аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль, 1978 онд Анагаах ухааны дээд сургуулийг Хүүхдийн их эмч мэргэжлээр, 1987 онд Бүгд Найрамдах Герман Улсын Фармакологийн институтыг Фармакологич мэргэжлээр, Анагаах Ухааны Их Сургуулийг Анагаах ухааны магистр зэргээр тус тус төгссөн, их эмч мэргэжилтэй, Анагаах ухааны магистр зэрэгтэй, клиникийн профессор.



**6.Ажилласан байдал:**

1978-1979 онд Ховд аймгийн Манхан сумын эмнэлэгт Хүүхдийн эмч, 1979-1986 онд Хүүхдийн нэгдсэн 2 дугаар эмнэлэгт Хүүхдийн эмч, амбулаторийн эрхлэгч, 1986-1993 онд Эм, био бэлдмэлийн улсын хяналтын газарт Фармакологич, фармакологийн тасгийн эрхлэгч, 1994-2000 онд “Магда” ХХК-ийн Ерөнхий захирал, 2000-2010 онд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, 2010 оноос одоог хүртэл “Магда” ХХК-ийн Ерөнхий захирал, Монголын сумын эмч мэргэжилтний холбооны тэргүүн, Монголын сүрьеэтэй тэмцэх нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн.


**7.Гадаад хэл:**

Орос, Англи хэлтэй.



### 3. Дашзэвэгийн ЧИМЭДДАГВА

- 1. Хэзээ, хаана төрсөн:** 1962 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2. Нас, хүйс:** 55 настай, эрэгтэй
- 3. Үндэс угсаа:** Халх
- 4. Гэр бүлийн байдал:** Эхнэр хүүхдийн хамт амьдардаг.



- 5. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**

1980 онд Нийслэлийн 10 жилийн 5-р дунд сургууль, 1985 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн факультетийг эдийн засагч-статистикч мэргэжлээр, 1995 онд Япон улсын Сайтама их сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэргээр тус тус төгссөн.

- 6. Ажилласан байдал:**

1985-1989 онд Статистикийн төв газарт мэргэжилтэн, 1989-1992 онд Төлөвлөгөө эдийн засгийн улсын хорооны мэргэжилтэн, 1992-1993 онд ЗГХЭГ-ын Эдийн засгийн бодлогын зөвлөлийн мэргэжилтэн, 1993-1996 онд Үндэсний статистикийн газрын Макро эдийн засгийн статистикийн газрын дарга, 1996-1997 онд ЗГХЭГ-ын Стратеги төлөвлөлтийн газрын дарга, 1997-1999 онд Хадгаламж банкны ТУЗ-ийн дарга, 1997-2000 онд Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга, 2000-2002 онд ЭМЯ-ны Стратеги төлөвлөлтийн газрын дарга, 2002-2006 онд тус яамны Санхүү эдийн засгийн удирдлага төлөвлөлтийн газрын дарга, 2008-2012 онд Эрүүл мэндийн сайдын орон тооны бус зөвлөх, 2014-2015 онд ЭЗХЯ-ХНБ-ийн “Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн ахлах зөвлөх, 2016 онд МУИС-ийн Эдийн засгийн судалгааны хүрээлэнд зочин судлаач, 2007-2017 онд Сангийн яамны “ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл”-ийн зохицуулагч, зөвлөх.

- 7. Гадаад хэл:**

Орос, Англи хэлтэй.